

**БАТЛАВ:**  
**ХОВД АЙМГИЙН**  
**ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ**  
**ДАРГА**                                          **С.ГАНТӨМӨР**

Огноо: **2020.05.18**

**ЗАМЫН ПОСТ БАРИХ /ЖАРГАЛАНТ СУМ/**

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Төслийн нэр:** ЗАМЫН ПОСТ БАРИХ /ЖАРГАЛАНТ СУМ/  
**Тендер шалгаруулалт**  
**/ гэрээний дугаар:** **ХОАОНӨГ/202001103**

**Ховд хот  
2020 он**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2020 оны 05 дугаар сарын 18

[*Жаргалант сумын ЗДТГазар*] нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [*Замын пост барих /Жаргалант сум/*]-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем буюу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээс үнэ төлбөргүй авах ба Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэх цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.

Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамжийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)-ээр банкны и-меркантын системийг ашиглан төлнө.

Үнийн саналыг [2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Улаанбаатарын цагаар 11 цаг 00 минутаас]-аас өмнө [[www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар, цахим хэлбэрээр] хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан [2020 оны 05 дугаар сарын 25]- ны өдрийн Улаанбаатарын цагаар [11 цаг 30 минутад]<sup>1</sup>-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **Эрхгүй**

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*[Хөвд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 107 тоот өрөө, Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн Ц.Энхтайван, Харилцах утас: 9526-1122]*

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b>          | <b>1.1.</b> Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>     | <b>2.1.</b> Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.<br><b>2.2.</b> Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                 | <b>3.1.</b> Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:<br><br>(а) Унийн санал;<br>(б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;<br>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;<br>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;<br>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |
| <b>4. Тендерийн үнэ</b>                       | <b>4.1.</b> Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.<br><b>4.2.</b> Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.<br><b>4.3.</b> Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.<br><b>4.4.</b> Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна. |
| <b>5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа</b> | <b>5.1.</b> Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш <b>45</b> хоногийн хугацаанд хүчинтэй байна.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>6. Алдааг залруулах</b>                    | <b>6.1.</b> Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:<br><br>(а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;<br>(б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |

- (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ Шалгуур узүүлэл</b>
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь Аймгийн засаг даргын захирамжаар эрх шилжиж ирсэн 50 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Замын пост барих /Жаргалант сум/ ХАОАНӨГ/202001103 дугаартай ажлыг гүйцэтгэх үнийн саналыг дараах мэдээллийн хамт ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар</li> <li>2. 2019 оны санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт;</li> <li>3. Борлуулалтын орлогын нийт мөнгөн дүнгийн жилийн дундаж: Сүүлийн 2 жилийн дундаж нь 50,000,000 төгрөгнөөс багагүй байна.</li> <li>4. Татварын тодорхойлолт (татварын бар код бүхий тодорхойлолт),</li> <li>5. Шүүхийн тодорхойлолт</li> <li>6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>7. Харилцагч банкны тодорхойлолт,</li> <li>8. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /шимтгэлийн өртэй эсэх, нийгмийн даатгалд шимтгэл төлдөг хүмүүсийн жагсаалт/,</li> <li>9. Ажлын төсөв ирүүлнэ /зураг төсвийн үнэ 700 000 төгрөгийг тусгана/</li> <li>10. Авах боломжтой зээл, эргэлтийн хөрөнгийн нийт дүн: Төсөвт өртөгөөс дээш.</li> <li>11. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд: <ul style="list-style-type: none"> <li>- Ачааны машин /Үйлчилгээний машин/</li> <li>-Шаврын тогоо /цахилгаан/</li> <li>- гэх мэт тухайн хийгдэх ажлуудад шаардлагатай техник болон тоног төхөөрөмжүүд</li> </ul> Дээрхи дурдсан машин механизмын тээврийн хэрэгслийн гэрчилгээг нотариатаар баталгаажуулан ирүүлэх. Түрээсийнх бол түрээсийн гэрээ ирүүлнэ.</li> <li>12. Албан мэдэгдэл /ТОӨЗ-нд заасан/ Байгууллагын тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш гаргасан байна.</li> <li>13. Ажил гүйцэтгэх хугацааны график ирүүлнэ.</li> <li>14. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах зөвшөөрөлтэй байна. Үүнд: Зам тээвэр, Барилга хот байгуулалтын яамны 2.1.1-/Барилгын засвар, засал, чимэглэл, орчны тохижилт/</li> <li>15. Ажлын төсөв ирүүлэх</li> <li>16. Ижил төстэй хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл, акт, гэрээний үргийн биелэлт</li> </ol>
ТОӨЗ 2.1	<p><b>Тендер хүлээн авах хаяг нь:</b>  Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтрэх цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ.  <b>Тендер шалгаруулалт / Гэрээний дугаар:</b>  Замын пост барих /Жаргалант сум/ ХАОАНӨГ/202001103  <b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа</b> нь 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Улаанбаатарын цагаар 11 цаг 00 минут байна. Энэхүү тендер нь цахим тендер тул тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим худалдан авах ажиллагааны систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>-ийн серверийн буюу <b>Улаанбаатарын цагаар тооцогдох</b> тул хугацаа хоцорсон тохиолдолд тендерийг хүлээн авах боломжгүй анхаарна уу.  Тендерт оролцогч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p>
ТОӨЗ 2.1	<p><b>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</b>  Тендерийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатарын цагаар 11 цаг 30 минут-д Ховд аймаг, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын байр, 107 тоот өрөөнд нээнэ. Харилцах утас: 9526-1122</p>
ТОӨЗ 6.2	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</b>  [Замын пост барих /Жаргалант сум/ ХАОАНӨГ/202001103]</p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

БАТЛАВ: ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА

С.ГАНТЕМӨР

ЖАРГАЛАНТ СУМ ЗАМЫН ПОСТ БАРИХ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Д/Д	Ажлын талбар	Хэмжих нэгж	Ажлын тоо	ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ
1	Зогсоол гаргах / 40x10 хэмжээтэй далан /	мкв	400	- Одоо байгаа 50 метр урттай 11өргөнтэй даланг уртаас 10 метр өргөнөөс 1 метр хасаж асфалтан замын түвшингээс 20см нам тэгшилэнз ус цацаж 16 тооны индуулж эрүүл мэндэж сайн нягтаршуулж өгнө.
2	Цутгалт хийх / 40x10 талбай/	мкв	400	Тэгшилэж нягтаруулсан 400 мкв талбайг М100 бетоноор 20 см зузаантай зутгаж өнгөлж өгнө.
3	Шат хийх	мкв	320	170 см өндөртэй далангын баруун хэсэгт 26 градус налуутай 120см өргөнтэй арматураар суур зангидаж М 250 бетоноор нэг гишгүүр нь 29 см өргөнтэй зутгаж өгнө.
4	Пост барих / 6x4 харицаатай /	мкв	24	6x4 хэмжээтэй палкан шувуун нуруутай нэг хаалгатай 3 ширхэг цонхтой байр бариж хийнэ. Гадан талдаа хөөсөн фасадтай байна. Дотор тал нь галд тэсвэртэй материалыар доторлож өгнө.
5	Бие засах газар хийх	мкв	18	1,5x4 метр хэмжээтэй 3 метрын гүнтэй нух ухаж байгалийн чулуугаар доторлож хөндөлөн 2 ширхэг 3 урттай палк тавиж өгж мөдөн кабин суулгаж өгнө.
6	Хашаа татах	м	11	4x5 хэмжээтэй хашааг 2 метр дутамд 40 диаметртai 180 см өндөртэй шонг 40 см нух ухаж суулгаж М100 бетоноор зутгаж өгнө шон хохонд галмэн темреер бүрж 4x4 уголник темреер 1:40 метр өндөртэй 90см өргөнтэй рам зангидаж галмэн темреер бүрж 2 ширхэг нугастай 1 ширхэг бариултай хийж өгнө.
7	Тэмдэг тэмдэглэгээ суулгах	ш	10	 <p>Стандарт хэмжээтэй шонтой тэмдэг тэмдэглэгээ далан доош 50см ухаж тэмдэгээ хийнэ бетонон зуурмагаар зутгаж өгнө.</p>

8	Хаяг	ш	2	<p>Үсэг бүр нь тусдаа лед гэрэлтэй авто замын хяналтын цэг гэсэн хаягыг постын байрны баруун талд 1 ширхэг, зүүн талд 1 ширхэг дээвэрт бэхлэж тогтоож өгнө. / захиалагчтай зөвшилцэж сонгон /</p>  <p>/жишээ зураг/</p>
---	------	---	---	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

## Шаардлага.

1. Гүйцэтгэгч нь ажлын талбайд гэрээ байгуулсаны дараа З хоногийн дотор Компаний товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажлын нэр, гэрзэний дүн, ажил эхлэх болон дуусах хугацаа зэргийг багтаасан мэдээллийн самбарыг олон нийтэд үзүүгэхүйц газар байрлуулсан байна.

2. Гүйцэтгэгч нь ашиглагч, захиалагч байгууллагуудтай уялдаатай ажиллах багеед гэрээнд заасан хугацаан дотор ажил гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

3. Гүйцэтгэгч үе шатны ажлын үед зохиогч болон захиалагчийг дуудаж далд ажлын акт үйлдэж баталгаажуулна.

4. Ажлын тоо хэмжээг гэрзэний өрөнхий болон тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт болон зурагтай холбож ойлгоно.

5. Ажлын тоо хэмжээнд тодорхойлсон магадлашгүй ажлын зардлыг зарцуулахад захиалагчийн зөвшөөрөл баталгааг авна.

6. Үндсэн ажлын тоо хэмжээнд тусгагдсан үнэ өртгийн ажлын тоог заасан заагаагүй, аль ч нөхцөлд тодорхойлсон байна. Гүйцэтгэгчийн бэглэөгүй орхисон үнэ өртэг, тодорхойлоогүй үлдээсэн ямар нэгэн ажил, түүний үнэ өртэг нь ажлын хэмжээнд тусгагдсан "бусад ажлуудад шингэсэн гэж ойлгоно.

7. Гүйцэтгэгч нь ажилтнууддаа хамгаалах хэрэгслээр бүрэн хангаж, тухайн орчин, ажлын байр, зам гарц, талбайг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэмд заасны дагуу бэлтгэж, үйлдвэрийн ослоос уридчилан сэргийлэх арга хэмжээг авч, хашаа хамгаалалт байгуулж, оршин суугчдийн зорчих хэсгийг техникийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж ажиллах ба үүнээс гарах хор хохирлыг вөрсдөө хариуцна. Байгалийн гэнэтийн гамшиг, гол түймэр, үер усны гамшигаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллана.

8. Ажлыг гүйцэтгэх үед тухайн орчны тохиижилт, холбоо, цахилгаан, интернетийн кабель утсыг гэмтээсэн тохиолдолд гүйцэтгэгч өөрийн хөрөнгөөр түргэн шуурхай засварлан хангагч байгууллагад хүлээлгэн өгнө.

9. Тухайн гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн 14.3, 14.6 дахь заалтуудын дагуу тохируулга, ашиглалтын хугацааны баталгааг бичгээр таргаж ирүүлнэ.

Хянасан: Дад бутэц

хариуцсан орлогч дарга:

Ц.Цогтбаяр

Боловсруулсан: Хотын захирагчийн

ажлын албаны мэргэжилтэн:

Я.Анхбаяр

Ховд аймгийн Жаргалант сумын Замын постын байрны ажлын төсөв

**АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ**

2020/04/28

Дл	А ж л б а р ы н и э р	Хэмжих нэгж	Тоо
<b>01. Газар широоны ажил</b>			
1.	Байгалийн хөрсийг тараар нүүн баримжаагаар тэгшгэх 2-р зэргийн хөрс	м2	151,50
2.	Ургамлын хөрсийг тараар хуулах /гэсгэлэн/2-р зэргийн	м2	18,23
3.	2м хүрглийг өргөн, 2м хүртэл гүн бэхжүүтэй шуудут 2-р зэргийн хөрсөнд тараар ухах	м3	18,81
4.	Шуудуу хүнхээл нүхийн 2-р зэргийн хөрсоор эргүүлж булах	м3	7,23
<b>02. Сууриний ажил</b>			
5.	Бетон блитгэл хийх м-100	м3	0,78
6.	Чулуу, тооцго, бетонон ханын тэгшгэсэн галаргуул ус тусгаарлагчийн бигум түрхэлжир 2 ус хийх	м2	58,60
7.	Бетон шугаман суурь цутгах М100	м3	9,23
<b>03. Хана хамар ханын ажил</b>			
8.	Хана хөөснөөр дулаалах б-150мм	м2	48,00
9.	180 мм-ийн зузаан дүнэээр хана хийх	м2	48,00
<b>04. Хучилтын ажил</b>			
10.	Зиамал модон ханатай барилгын балзан бамбай зуланчтай модон хучилт хийх	м2	45,00
<b>05. Дээврийн ажил</b>			
11.	Каркасан ханыг пергамин паасавр бүрэх	м2	24,00
12.	Адрин бамбай зуланчтай модон хучилт угсарт эрдэс хөөн хавтангаар дулаалга хийх	м2	24,00
13.	Керамзит хайргаар дээврийн дулаалга хийх	м3	1,44
14.	Шувуун иуруун бүтнүүд угсрал	ш	1,00
15.	Модон сараалжтай долгионт төмөр дээвэр хийх	м2	30,00
<b>06. Шалны ажил</b>			
16.	Бетон блитгэл хийх М50-75	м3	2,40
17.	20 мм зузаан цементэн тэгшигээ хийх	м2	24,00
18.	Дулаалгатай паркетан шал хийх	м2	24,00
<b>07. Хаягла , цонхины ажил</b>			
19.	1,5x1,8 хэмжээтэй давхар шил суудаг данжан тай пластмасан цонхыг өргөгчөөр хинанд суулгах	блок	2,00

Ховд аймгийн Жаргалант сумын Замын постын байрны ажлын төсөв

Д/д	А жил барын - иэр	Хэмжих илж	Тоо
20	2м <sup>2</sup> хүртэл талбайтай бүргэд халга суулгах	ш	1.00
21	Хамар хана ба заамал биш модон хананд 3 м <sup>2</sup> хүртэл талбайтай гадна дотор халга угзрах	м <sup>2</sup>	2.10
<b>08. Дотор засалын ажил</b>			
22	Хөнгөн цагаан рамтай 60х60 хэмжээтгэй дүүжин таазыг хавчаар ба темөр угсаар зүх	м <sup>2</sup>	24.00
23	Тосон булаар будах ханыг төлтэнэ хуудсаар өнгөлж хуурай шавардлагыг хийх	м <sup>2</sup>	78.50
24	Будалтанд бэлтэсэн угсармал хийцэд гадаргууд 3 р үеийн тэснүүцээ хийх	м <sup>2</sup>	78.50
25	Шавардсан хана өнгийн тосон будагаар гар аргаар сайн чанартай будах	м <sup>2</sup>	78.50
<b>09. Гадна засалын ажил</b>			
26	200мм хүртэл оргөн муруй амалгаат өндөр чанартай шавардах	у/м	16.20
27	Амалгаа эмульсиин будгаар гар аргаар будах	м <sup>2</sup>	8.60
28	Хананд төр татаж сайн чанарын шавардлагыг хийх	м <sup>2</sup>	54.20
29	Будалтанд бэлтэсэн угсармал хийц , шавардсан гадаргууд 3 р үеийн тэснүүцээ хийх	м <sup>2</sup>	54.20
30	Гадна хана усан эмульсиин будгаар гар аргаар будах	м <sup>2</sup>	54.20
<b>10. Бусад ажил</b>			
31	Бетон хаявч цутгах м-100	м <sup>3</sup>	4.21
<b>11. Дотор гэрэлтүүлэгчийн ажил</b>			
32	2 судастай 16мм <sup>2</sup> хүртэл огтлонгой утас татах	м	50.00
33	Тоосгон барилгад 4 хүртэл лампийг өдрийн гэрэлтүүлэг тавих	ширхэг	2.00
34	Ил угзрах унтраалга тавих	ширхэг	2.00
35	Сониур залгур ил тавих	ширхог	2.00
36	8 хүргэл автоматтай гэрэлтүүлэгчийн самбар болги нүхэнд угзрах	ш	1.00
37	Хуванцар хоолойгоор утас дадлагах2	метр	50.00
<b>12. Халаалт</b>			
38	Халаалтын кабелдтай бетон шал хийж паркетан шал наах	м <sup>2</sup>	24.00
<b>13. 40х10м хэмжээтгэй авто зогсооны ажил</b>			
39	Эксковатороор 2-р төргийн хөрсний ухаж широог автосамосвалд ачижж 5 км -ээсээж авч ирх	м <sup>3</sup>	1,200.00
40	50см зузаан үеир хөрс нягтруулагч машиннаар нягтруулах	м <sup>3</sup>	1,200.00
41	Дадалгийн ул хөрсний нягтруулах	100м <sup>3</sup>	12.00
42	Авто зогсоол 250 маркийн бетоноор 20 см зузаан цутгах	м <sup>3</sup>	80.00
<b>14. Шат</b>			
43	Шатны томор бетон гишгүүр чигжиж цутгах	м <sup>3</sup>	1.00

Хөвд аймгийн Жаргалант сумын Замын постын байрны амслын тоосын

№	Ажилбарын нэр	Хэмжих илж	Тоо
<b>15. 4x5 м хэмжээтгэй томор төрөн хашаа</b>			
44	Хашааны шонгийн нүх гараар ухах	м³	1.20
45	Хавсны шон суулгах	шт	9.00
46	Төмөр сараалжин хашаа 4x5 м h=1.6 м хийж уграх	м²	28.80
<b>16. Бие засах газар</b>			
47	Нүх гараар ухах	м³	2.40
48	Бие засах газрын дотор ханаг чулуугаар доторлох	м³	1.80
49	Модон жорлон барих	1шт	1.00
<b>17. Тэмдгүүртэй хийх</b>			
50	Авто замын тэмдгүүрийн байрлуулалт	1шт	10.00
<b>18. Гэрэлтэй самбар</b>			
51	Авто замын хяналтын цэг гэсэн лед гэрэлтэй бичигтэй самбар уграх	1шт	2.00
<b>99.Хог хангалын дун</b>			
52	Хог хангдал	тн	0.00

Хөвд аймгийн Жаргалант сумын Замын постын байрны ажлын тоосад

## Тав. Зураг

### Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

#### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

##### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарыт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыт заавал оруулна.

##### Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцгчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцгчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

##### Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамжс нь зөвхөн захиалагч болон тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон усгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний өрөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |                                                             |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.                                                                                                                                                                                                                                                                                                                                    |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br><br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.                                                                                                                                                                 |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>                                    | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br><br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b>                         | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.                                                                                                                                                                                                    |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>                          | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>2</sup> дуусгахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br><br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.                                                                                                                             |

<sup>2</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

<b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b>	10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.
	<b>В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ</b>
<b>11. Үе шатны ажлын хуваарь</b>	11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
	11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
<b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b>	12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
<b>13. Алданги</b>	13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги <sup>3</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
	<b>Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>
<b>14. Ажил дуусгах</b>	14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлзуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
<b>15. Хүлээж авах</b>	15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
<b>16. Эцсийн тооцоо</b>	16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
<b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага</b>	17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

<sup>3</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоон. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

## Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>4</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Замын пост барих /Жаргалант сүм/ ХОАОНӨГ/202001103 ]</i>
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь <i>[техникийн тодорхойлолт, зураг, төсөв, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]</i> -аас бүрдэнэ.  Ажлын талбай нь <i>[Жаргалант сумын Бичигт баг]</i> -д байршил болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь <i>[Дэд бүтэц хариуцсан орлогч дарга Ц.Цогтбаяр]</i>
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр <i>[2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр]</i>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <i>[2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр]</i> <sup>5</sup>
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <i>[5]</i> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа <i>[365]</i> хоног байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <i>[хувь]</i> байна. <sup>6</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <i>[10 хувь]</i> байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <i>[огноо]</i> -ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <i>[мөнгөн дүн]</i> байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <i>[хувь]</i> -иар тооцно.

<sup>4</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.  
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>5</sup> Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

<sup>6</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

*[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.*

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

**1.** Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцгэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

**2.** Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

**3.** Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

**4.** Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

**5.** Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний өрөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;

- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :  
**5.9.** Санхүүжилтийн хуваарь;  
**5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]